

БҮШИДО – ЁС ЗҮЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

Д.Оюунгэрэл (Доктор Ph.D)
Философи, шашин судлалын тэнхим, МУИС

Түлхүүр үг: ёс суртахуун, хүндлэл, шударга ёс, эр зориг, тэвчээр, өрөвч, хүнлэг энэрэнгүй чанар, чин эрмэлзлэл, хариуцлага, нэр төр

Товч утга: Японы үндэсний үзэл бүшидо (武士道) нь япончуудын ёс суртахууны сургаалын онцлогийг харуулах нэгэн чухал сургаал билээ. Тиймээс бүшидо бол ёс суртахууны сургаалын хувьд япон үндэстний бэлгэ тэмдэг гэж хэлж болно. Бүшидо гэдэг нь бүши буюу самүрай, цэрэг дайчин, до буюу зарчим, зам мөр, арга ёс гэсэн хоёр үгнээс гаралтай дайчин эрсийн ажил, амьдралдаа мөрдөх зарчим гэсэн утга бүхий үг ажээ. Анхандаа бүшидо нь бүши нарын баримтлах ёс суртахууны хэм хэмжээ, дүрэм журам байсан. Гэхдээ энэ бол хуульчлагдсан дүрэм журам биш, монголчууд бидний ойлголтоор бичигдээгүй хэв хууль байсан юм. Самүрай нар бүшидо гэсэн ертөнцийг үзэх тусгай үзэл, биеэ авч явах бичигдээгүй хууль байжээ. Тэрхүү ёс журам нь самүрайн оршин тогтнох үндэс суурь болж байсан гэдэг. Харин эдүгээ бүшидо нь хатуу дэг журам бус, жирийн япон хүн бүрийн өдөр тутмын амьдралдаа баримтлан хэрэгжүүлдэг ёс зүйн үзэл болон төлөвшилээ.

Дашрамд өгүүлэхэд япончууд аливаад хүндэтгэлтэй хандах, хүнийг хүндлэх, хөдөлмөрийг үнэлэх, бусдад саад болохгүй байх, үндэсний зан заншил, ёс төрөө эрхэмлэх талаар үнэхээр үлгэр жишээ бүхий бөгөөд үүгээрээ ямагт бахархдаг үндэстэн билээ. Энэ бахархлын үндэс нь бүшидо ёс суртахууны сургаал юм. Тийм ч учраас өнөөгийн нийгэмд ч япончууд ёс зүйн боловсролд өндөр ач холбогдол өгч нягт нямбай ханддаг байна. Энэ талаар доктор Р.Дарьхүү, Б.Оюунцэцэг нар “Ёс зүйн боловсролын асуудалд” өгүүлэлдээ тэмдэглэхдээ: “Японд ёс зүйн боловсрол нь бага ангиас ахлах ангийн суралцагч хүртэл зайлшгүй мэдвэл зохих асуудлуудыг багтаасан нарийн боловсруулсан хөтөлбөрийн дагуу хэрэгждэг”¹ гэжээ. Ийнхүү японд энэхүү боловсролыг хүүхдийн нас, сэтгэхүй, сэтгэл зүйн хөгжлийн онцлогт тохируулан тодорхой төлөвлөгөөтэйгөөр өөрийн үндэсний сургаалаар дамжуулан хэрэгжүүлж, амжилтад хүрч байгаа туршлагаас бид

суралцах хэрэгтэй байгаа юм.

Хөгжлийн нууц нь болсон тэдний ёс суртахууны сургаалын гол утга учир юунд оршдог вэ?

“Самүрай анги давхарга албан ёсоор японы нийгмийн дээд анги давхарга болж байхад энэхүү бүшидо хэмээх ёс журмыг баримтлан мөрдөж байсан бөгөөд бусад анги давхарга ч энэхүү ёс зүйн, хүнлэг ёсны, зан суртахууны зарчмыг даган мөрдөж байсан учраас бүшидог япон үндэстний ёс зүйн цогц”² гэж хэлж болно. Бүшидо ёсны гол агуулга нь анх “Бусдад шударгаар захирагдах ёс буюу өөрийн эзэн ноёндоо үнэнч шударгаар үйлчлэх, үүргээ нэр төртэй биелүүлэх, өөрийн ойр шадар хүмүүсийн сайн сайхны төлөө тэмцэх, тэвчээртэй байх”³ зэргээр тодорхойлогддог байв. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр энэхүү сургаал нь нийгмийн анги давхаргыг төлөөлөхөө больж, нийт хүмүүсийн ажил амьдралдаа

¹ Дарьхүү Р. Оюунцэцэг, Б. (2009). Ёс зүйн боловсролын асуудалд. “Философи, шашин судлал” Эрдэм шинжилгээний сэтгүүл. №308 (51): 114

² Төмөрбаатар Д. Орчуулагчийн үг. /Нигтобэ Иназо. 2007. Бүшидо-япон үндэстний ёс зүйн цогц/ Улаанбаатар. 7 дахь тал

³ Золзаяа, М. (2009). Бүшидо - ёс зүйн сургаал. “Философи, шашин судлал сэтгүүл”. №308 (51): 42

мөрдөх ёс зүйн сургаал болсон байна.

Бүшидо – ёс зүйн гол ойлголтуудыг нэрлэвэл:

1. gi (義 gi) -шударга ёс,
2. rei (禮 rei)– хүндлэл,
3. yu (勇 yū) – тэвчээр,
4. jin (仁 jin)- хүнлэг энэрэнгүй чанар,
5. makato (誠 makoto) - чин эрмэлзлэл,
6. chu (忠義 chūgi)- үнэнч зан,
7. meiyō – (名譽 meiyō) нэр төр зэрэг болно.

Самүрай хүн гэхээр л сэлэм барьсан өөрт таалагдаагүйгээ цавчдаг хүн байгаагүй ажээ. Хэдийгээр өстөн дайснууд байлаа ч аливаа сайн, шударга зүйлд хүнлэг хандахыг багаас нь заадаг ажээ. Бүшидо ёсоор самүрай нар хүмүүст өрөвчхөн, бас хүнлэг хандах ёстой. Хүч тэнхээ нь хүрэлгүй ялагдсан дайсандаа ч хүний ёсоор тэвчээртэй хандахыг самүрай нарт сургадаг байна. Энэ бол бүшидо сургаал дахь jin хэмээх ойлголт бөгөөд хүнлэг энэрэнгүй чанарыг илтгэсэн ойлголт мөн.

Хүн байхын нэг чухал чанар бол шударга явдлыг эрхэмлэх явдал бөгөөд энэ тухай өрнийн философид Сократ “Шударга ёс бол бусдад үйлдэх буян юм. Шударга бус байна гэдэг нь доройн шинж” хэмээсэн энэ утга бүшидо сургаалд мөн байдаг. Аль ч үндэстэн шударга ёсыг эрхэмлэсэн ёс суртахууны сургаал номлолтой бөгөөд тэр дундаа бүшидогийн хувьд шударга ёс бол бүши хүний амьдралынх нь суурь зарчим юм. Тиймээс бүши хүний хувьд шударга бус байх нь хамгийн дорд үйлдэл байдаг. Шударга чанар бол ёс журамдаа тулгуурлан аливааг эргэлзэхгүйгээр шийдэх сэтгэл юм гэж бүшидод үздэг ба шударга, шулуун зан чанарыг gi хэмээх ойлголтоор илэрхийлнэ.

Самүрай нарт үнэнч шударга ёс, нэр төр хамгийн үнэт зүйл байсан. Тэдний нэр төр ямар нэг байдлаар хөндөгдвөл амиа золиослоход бэлэн байх учиртай. Харин бүши хүн нэр төрөө эрхэмлэн үзэхийг

туйлаас чухалчилсан байна. Тухайлбал, “Дуудах нэр бол өөрт бий болсон арилшгүй зүйл”⁴ хэмээсэн нь өөрийн эрх хийгээд үүргээ ямагт ухамсарлан хүмүүжих нь бүши хүний суурь зарчим байжээ гэж хэлж болно. Бүшидо сургаалд нэр төрийг meiyō хэмээх ойлголтоор илэрхийлдэг. Хүний нэр төрд халдахыг хамгийн ичгүүртэй зүйл гэж үздэг. Энэ нь ичих эмээх мэдрэмжгүй хүний хийдэг үйлдэл ажээ. Тиймийн тул нэр төрд халдах, мөн нэр төрөө алдахаас ихэд эмээдэг байна.

Бүшидо ёс зүйн сургаал нь шударга ёс, хариуцлага, үнэнч тууштай зан, тэвчээр зэргээр тулгуур баганаа болгодог гэж хэлж болно. Тэрхүү тулгуур баганыг илэрхийлдэг нэг ойлголт бол chu – үнэнч зан юм. Самүрай нар худал хэлэхийг хатуу цээрлэнэ. “Бүши но ичигон” /武士の一言/ буюу “бүши хүний нэг үг” хэмээх нь монголчуудын хэлдэгээр за гэсэн бол ёогүй гэсэн утгатай үг юм. Улмаар явсаар “самүрайн үг буцалтгүй нандин” гэсэн зүйр үг болжээ. Тиймээс самүрайн хэлсэн үг нь амлалт мэт бөгөөд энэ нь шударга үнэний баталгаа болдог. Энэ нь тэднийг хийсэн үйл хэрэг, хэлсэн үгэндээ эзэн болж жижиг ч бай том ч бай аливаа зүйлд өөрөө хариуцлагатай ханддагийг илэрхийлж байгаа юм. Бүши хүн бол бичгээр баталгаа гаргадаггүй, хэрвээ цаасан дээр бичнэ гэвэл түүнийг шархлуулсан хэрэг гэж үздэг байна. Хүн нугаршгүй эр зоригтой байх гол шаардлагаас гадна үүрэг хариуцлагаа ухамсарласан байх, тэвчээр зэрэг нь бүшидогийн амин сүнс юм. Энэ чанар нь эгзэгтэй хүнд үед эзнээ орхидоггүй, бие бялдрын хатуужил, улмаар үхлийг ч тайвнаар хүлээх сэтгэлийн тэнхээ бий болгож чаддаг ажээ. Эртний Грекийн сэтгэгч Платон “Тэвчээр гэдэг нь өөрийгөө эзэмдэх, өөрийнхөө зовлон жаргалд эзэн болох чадвар” гэсэн байдаг.

Хатуужил тэвчээр бол бүши нарын хамгийн их хүндлэл хүлээсэн чанар байжээ. Энэ чанарыг yu – эр зориг, тэвчээр хэмээх ойлголт илэрхийлнэ. “Ходоод хоосон

⁴ Нитобэ Иназо. 2007. Бүшидо-япон үндэстний ёс зүйн цогц. Төмөрбаатар, Д. (орч), Улаанбаатар. 187 дахь тал

самүрай хүү өлсөж байгаага мэдрэх шиг ичгүүртэй явдал байхгүй” хэмээн хатуужил тэвчээрийн тухай сургадаг байна. Хатуужил тэвчээрийн илрэл нь тайвшрал байдаг. Тиймээс хатуужил тэвчээртэй хүн бол оюун санааны тайвшралыг олсон байдаг бөгөөд ямар үед тухайлбал, ширүүн тулаан, гал түймэр, газар хөдлөлт, үймээн самууны үед сандарч хашгирахгүй байж чаддаг байна.

Бусдыг хүндэтгэх, тэдний зовлонг мэдрэхээс бий болох зан чанар бол угтаа нинжин сэтгэл юм. Баатарлаг хүн хамгаас уян зөөлөн байдаг, хайрыг хамгийн ихээр агуулсан хүн зүрх зоригтой байдаг ажээ. Энэ бол *tei* – хүндлэл болно. Тэд зөвхөн ухаалаг эр зоригийг дээдэлдэг. Харин амиа утга учиргүй алдахыг үл зөвшөөрнө. Утга учиргүй, зорилгогүй үхлийг “нохойн үхэл” гэж үздэг байжээ.

Орчин үед бүшидо сургаалаас ёс суртахууны үнэт зүйлийг гарган тайлбарласан олон сэтгэгч байдаг. Бүшидо сургаал дахь хүнлэг энэрэнгүй сэтгэл, үнэнч шударга байдал, хариуцлагатай байх, тэвчээртэй байх зэрэг бол хүний ёс суртахууныг илэрхийлэх, түүнийг удирдах зарчим болохыг онцлон авч үзсэн сэтгэгч бол Нишида Китаро бөгөөд тэрээр өөрийн ёс зүйн сургаалдаа энэ тухай онцлон үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл, аливаа хүн ёс суртахууны тодорхой чадваруудыг тухайлбал, бусдын амьдралд саад учруулахгүй байх чадвар, бэрхшээлийг даван туулах чадвар, өөрийгөө хөгжүүлэх чадвар гэх мэт чадварыг эзэмшсэн байх ёстой. Мөн Нитобэ Иназо өөрийн бүтээлдээ: “Яг үнэндээ бол муу ч бай сайн ч бай биднийг хатган өдөөж ирсэн хүч бол цэвэр, энгийн бүшидо байсан юм”⁵, “... би багадаа олж авсан ёс зүйн эрдэм мэдлэг.... юуг сайн, юуг муу гэх, түүнчлэн юуг зөв юуг буруу гэхийг надад ер хэн зааж өгсөн юм бэ? ингээд л би сайн муу, зөв бурууг задалж нэг, нийлүүлж нэг үзсээр байгаад эцэстээ энэ бүхнийг надад анх бүшидо л мэдүүлж, нүдийг минь нээжээ гэдгийг

ойлгосон”⁶ хэмээн бүшидогийн үүргийг илэрхийлсэн байна.

Эдгээр нь тухайн хүний нийгэмд амьдрах чадварыг илтгэнэ гэж үзэж байсан нь угтаа бүшидогоос уламжлан авсан, түүний үнэт зүйлсийг тунгаан өөрийн сургаалаа боловсруулсан хэрэг болно.

Нишида Китаро “Шударга байх, тэвчээртэй байх, үнэнч байхыг зөвхөн бүши буюу самүрай хүний эрхэм чанар биш”⁷ хэмээгээд, эдгээр чанар бол хүн бүрийн баримталвал зохих чухал чанар болохыг онцолж байсан нь Мейжийн шинэчлэлийн үед бурангуй ёсыг халах соён гэгээрлийн чухал алхам болж биелэлээ олжээ.

Үнэхээр ч япончууд гаднаас нь харахад тайван, ямагт бие биетэйгээ болон гадаад хүмүүстэй хүндэтгэлтэй харьцдаг, сэтгэлийн огцом илрэлээ ил гаргадаггүй хүмүүс билээ. Тиймээс тэд аюул нүүрлэсэн ч, гамшигт өртөж орох оронгүй болсон ч чимээгүйхэн, эмх журамтай байж чаддаг нь үнэхээрийн гайхамшигтай тэвчээрийг харуулдаг. Тэд асуудлыг гадагшаа хандахаасаа илүү өөрөө өөртөө хандаж шийдлийг эрдэг нь зэнгийн сургаал болон бүшидо ёстой холбоотой.

Орчин үед ч бүшидо нь үндэстний хэмжээнд хүн бүрийн хэрэгжүүлэх ёс суртахууны сургаал, ёс зүйн нийтлэг зарчим болон хувирчээ. Зарим хатуу гэмээр дүрэм журмууд нь орчин цагийн нийгмийн хөгжлийг дагаад өөрчлөгдөн хувирч, хоршин зохицсон байна. Тухайлбал, зарим компани бүшидо сургаалын агуулгыг өөрсдийн дүрмээр дамжуулан ажилчдын ёс суртахууны зарчим болгон ашигладаг байна. Жишээ нь: унадаг дугуй үйлдвэрлэдэг нэгэн компанийн сүлд дуунд:

*Далайн хүчтэй давалгаа далайн эргийг
бүрхсэн ч*

Зүрх нэгтэй ахан дүүс хамтын хүчээр

*Сул талаа сэлбэн, хүчирхэг талаа
хөгжүүлэн*

⁵ Нитобэ Иназо. 2007. Бүшидо-япон үндэстний ёс зүйн цогц. Төмөрбаатар Д. (орч), Улаанбаатар. 187 дахь тал

⁶ Мөн тэнд. 19 дэх тал

⁷ Nishida Kitaro. 1973. Art and Morality, David Dilworth and Valdo Viglielmo (trans.), Honolulu. 13 pp

*Зөв амьдралыг хүчээр, өгөөмөр сэтгэлээр
чулуу шиг л тэсвэртэй үлдэнэ*

*Бидний ахан дүүс гал, усан дундуур ч явна
Зүрх нэгтэй ахан дүүс бид*

*Нүд гялбам амжилтын дундуур хичээл
зүтгэлийнхээ ачаар*

*Үргэлж гялалзаж байх болно*⁸ хэмээн илэрхийлсэн байх бөгөөд үүгээр зогсохгүй бүшидо – ёс зүйн үзлийн утга бүр нь орчин үеийн япон компаниудын ажлын байрны ёс зүйн зарчим болон хувирчээ.

Бүшидо нь судлаачид, эрдэмтдийн судалгааны ажлын эх сурвалж, нэг хэсэг болохын сацуу жирийн япон иргэдийн амьдралын хэм хэмжээг залсаар байгаа ажээ. Үүний нэг бодит баримт бол Нишида Китарогийн ёс зүйн үзэл юм. “Сайн үйлийн тухай сургаал” /善の研究/ хэмээх бүтээлдээ тэрээр ёс зүйд ихэд анхаарч, хүний амьдралын ёс суртахууны асуудлыг онцлон авч үзэж байсныг харж болно.

Тэрээр энэ бүтээлдээ “зэн” /сайн үйл/ /善/ гэдэг ёс зүйн ойлголтыг боловсруулсан. Энэ ойлголт бол “тухайн хүний ёс суртахуунлаг зан төрхийг илэрхийлэх төдийгүй, мөн үнэмлэхүй хоосонтой нэгдэх үндсэн нөхцөл мөн. Түүнчлэн үнэнхүү бодгал чанарын төгөлдөржилт болохын сацуу бүх хүн төрөлхтний сайн сайхан байдалд түшиглэх ганц суурь”⁹ юм. Нишида Китарогийн хувьд сайн үйл гэдгийг хүний ёс суртахуунлаг зан төрх оршихуйн үндэс болох тухай санаа тод ажиглагдана. Өөрөөр хэлбэл, түүний философи дахь энэ ойлголтын гол утга санаа нь хариуцлага, шударга байх, чин эрмэлзлэл зэргээр тодорхойлогддог нь бүшидо-ёс зүйн үзлээс эхлэлтэй.

Соён гэгээрүүлэгч Фүкүзава Юкичи (1835-1901) хэлэхдээ: “Хүмүүс угаас адил төрөлхтөн болохын хувьд нэгэн тэнгэр газрын дунд амьдарч насыг элээдэг. Тиймээс харилцан бие биенээ хайрлан хүндэтгэж,

өөр өөрсдийн үүрэг хариуцлагыг биелүүлж, бусдад садаа болох ёсгүй”¹⁰ хэмээсэн байна. Ийнхүү бусдын амьдралд саад учруулдаггүй байх чадвар бол өөрийн хүрээлэн буй орчин гэр бүл, хамт олон, найз нөхөд болон бусад хүмүүст саад учруулахгүй байх зан төлвийг эзэмших гэсэн утгаас гадна ирээдүй хойч үедээ саад тотгор болохгүй байх гэсэн өргөн утга агуулгатай үзэл юм. Хүн амьдралынхаа туршид эхлэн хэнд ч саад бололгүйгээр, эрх чөлөөтэй амьдрах учиртай билээ.

Дүгнэлт: Философи бол ойлголтоор сэтгэх ухаан мөн. XX зууны японы философийн нэгэн чухал зорилт бол өөрийн гэсэн үндсэн ойлголтуудыг бий болгох явдал байсан болно. Японы сэтгэгчид энэ тал дээр идэвхийлэн ажиллаж, тодорхой амжилтыг олсон бөгөөд тэд уламжлалт философийн үндсэн дээр өрнийн философийн ололтуудыг шингээн авч орчин үеийн нийгэмд тохирсон шинэ үзэл санаа дэвшүүлэхийг зорьж байжээ. Энэхүү зорилтыг япон үндэстний ёс зүйн сургаал номлолд хэрэгжүүлсэн хүн бол Нитобэ Иназо юм. Тэрээр бүшидо бол ёс зүйн тодорхой бие даасан сургаал номлол болохыг нотлон илэрхийлэхийг оролдож, тодорхой ойлголт категориудыг жишээ баримттай тайлбарлажээ.

Бүшидо боляпончуудын ёс суртахууныг гэрэлтүүлэн залсаар байгаа тухай, ерөөс ёс суртахуун бол аливаа ард түмний хөгжлийн түлхүүр болох тухай өөрийн “Бүшидо-япон үндэстний ёс зүйн цогц” бүтээлдээ авч үзээд цаашид ч япончуудын амьдрал ахуйг зохицуулагч, урагшлуулан жолоодогч гол хүч болохыг тэмдэглэсэн байна.

Улс орон хөгжихийн тулд сургууль, армиар дамжуулан хувийн эрх ашгийг жигших, өндөр хариуцлагатай байх, хувиа үл хичээх, шударга байх тухай зааж, ёс суртахууны боловсрол болгох хэрэгтэйг япончууд онцолдог. Тэд орчин үеийн өндөр хөгжил дэвшилд хүрсэн өнөөгийн байдлаа өөрсдийн ёс суртахууны сургаалтай холбон тайлбарладаг нь анхаарууштай.

⁸ Японы үндэсний үзэл. 2010. Энхсайхан, М. (орч), Улаанбаатар. 148 дахь тал

⁹ Оюунгэрэл Д. (2010). Сайн үйл нь хүний амьдралын үндэс болох тухай Нишида Китарогийн үзэл. Philosophy: “Theory and Practice”. The international scientific conference. 1:257

¹⁰ Фүкүзава Юкичи. 2004. Эрдмийг эрхэмлэх ухаан. Орч., О. Жаргалсайхан. Улаанбаатар. 21 дэх тал

НОМ ЗҮЙ

1. Р.Дарьхүү. Б.Оюунцэцэг. Ёс зүйн боловсролын асуудалд. “Философи, шашин судлал” сэтгүүл. 2009. №308 (51)
2. Нитобэ Иназо. Бүшидо-япон үндэстний ёс зүйн цогц. Орч., Д.Төмөрбаатар УБ., 2007
3. М.Золзаяа. Бүшидо - ёс зүйн сургаал. “Философи, шашин судлал сэтгүүл”. 2009. №308 (51)
4. Д.Оюунгэрэл. Сайн үйл нь хүний амьдралын үндэс болох тухай Нишида Китарогийн үзэл. Philosophy: “Theory and Practice”. The international scientific conference. 2010
5. Japanese Philosophy A Sourcebook. Edited by James W.Heisig, Thomas P.Kasulis, John C.Maraldo. 2011
6. Фүкүзава Юкичи. Эрдмийг эрхэмлэх ухаан. Орч., О.Жаргалсайхан. УБ., 2004.
7. “Bushido (Japanese History).” Encyclopedia Britannica. 2004
8. “Japan The Bushido Code.” Japan The Bushido Code. 2000
9. McGee, Mark. “Brief History of the Samurai.” Brief History of Samurai.
10. “Origin of Samurai About.com.” Samurai History in Japan. 1993

of ethics. It created a common belief that all of the men would follow and also meant there was more order and law in Japan. As it grew, it started to influence everyone in Japan and became a common belief that everyone respected.

ABSTRACT

The author of this paper intended to show that importance of concept of Bushido soul. Today wherever you look in modern Japan you will find some of the values of Bushido. Japanese have the highest value, respect, honor, integrity, duty and loyalty to their country and families.

Bushido was important to Japanese soldiers because Bushido is a generally equivalent to a code of ethics and morals for warriors. But Bushido very quickly created a fighting force that followed a very clear code